



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/179

Хэрлэн сум

Мал эмнэлгийн халдварт өвчнөөс  
урьдчилан сэргийлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 9 дүгээр зүйлийн 9.1-9.9, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 34 дүгээр зүйлийн 34.2.2 1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны "аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоол, 2021 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны "аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин био бэлдмэл, тарилга, үйлчилгээний зардалд 572,642,100 (таван зуун далан хоёр сая зургаан зуун дөчин хоёр мянга нэг зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийн 409,830,000 (дөрвөн зуун есөн сая найман зуун гучин сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 162,812,100 (нэг зуун жаран хоёр сая найман зуун арван хоёр мянга нэг зуун) төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, мал эмнэлгийн арга хэмжээнд шаардлагатай вакцин, эм урвалж, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ